



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/308

Хэрлэн сум

Төсөл арга хэмжээний гэрээ байгуулах
болон худалдан авах ажиллагаа зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.6, 8.7, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А/11 дүгээр тушаалын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасан IV.1.12 дугаартай батлагдсан "Их хуралдай" цогцолборын барилгын зоорины ажил, гадна тохижилт, шугам сүлжээ (Хэнтий, Биндэр сум) төсөл арга хэмжээний гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсугай.
2. Төсөл арга хэмжээнүүдийн гэрээ байгуулах дүнг хавсралтаар баталсугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 24-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Багцын дугаар	Багцын нэр	Төсөвт өртөг	2022 оны санхүүжилт (сая төгрөг)	2023 оны санхүүжилт (сая төгрөг)
Багц 1	"Их хуралдай цогцолборын барилгын зоорийн ажил"	529,935,397.00	102,804,000.00	427,131,397.00
Багц 2	"Их хуралдай цогцолборын гадна тохижилт, шугам сүлжээ (Хэнтий, биндэр сум) "	2,338,764,603.00	292,596,000.00	2,046,168,603.00